



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/125

Улаанбаатар хот

Журам батлах тухай

МУИС-ийн Дүрмийн 4.3.1, МУИС-ийн 2016-2024 оны Стратегийн төлөвлөгөөний 4.1 дүгээр зорилт, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "МУИС-д Эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн хэвлүүлэхэд баримтлах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журамд заасан эрдэм шинжилгээний сэтгүүлд тавигдах шаардлагад нийцүүлэн эрдэм шинжилгээний сэтгүүлээ сайжруулан эрхлэн гаргахыг сэтгүүлийн ерөнхий редакторуудад үүрэг болгосугай.

3. Эрдэм шинжилгээний сэтгүүлийг сайжруулахад дэмжиж ажиллахыг судалгааны төв, хүрээлэнгийн эрхлэгч, бүрэлдэхүүн болон салбар сургуулийн захирлууд, Эрдэм шинжилгээний хэлтсийн дарга /Г.Амарсанаа/-д үүрэг болгосугай.

4. Батлагдсан журмын дагуу МУИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийг үнэлж МУИС-иас эрхлэн гаргах эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалтыг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор МУИС-ийн Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэхийг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал /Ч.Лодойравсал/-д үүрэг болгосугай.

5. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал /Ч.Лодойравсал/-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОЧИРХУЯГ

3340501048

Захирлын 2021 оны 06 дугаар сарын 04-ны  
өдрийн 11 дугаар тушаалын хавсралт



## МУИС-Д ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛ ЭРХЛЭН ХЭВЛҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар сургууль, судалгааны хүрээлэн, төвийг түшиглэн гаргах эрдэм шинжилгээний сэтгүүлд тавигдах шаардлага, хэвлэлийн бодлого, хэвлүүлэхэд баримтлах зарчим, санхүүжилт, нийтийн хүртээл болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 Эрдэм шинжилгээний сэтгүүл нь шинжлэх ухааны шинэ мэдлэгийг түгээхэд Монгол улсад тэргүүлэгч байх эсвэл олон улсад өрсөлдөх МУИС-ийн сэтгүүл байхыг эрмэлзэнэ.

1.3 Эрдэм шинжилгээний сэтгүүлийг шинээр бий болгох, бүртгүүлэх, редакцийн зөвлөлийг байгуулах, хэвлэх, олон нийтийн хүртээл болгоход энэхүү журмыг баримтална.

1.4 Энэхүү журамд дурьдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

1.4.1 “Эрдэм шинжилгээний сэтгүүл” гэж шинжлэх ухааны хөгжлийг дээшлүүлэх, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор туршилт судалгааны шинэлэг үр дүнг эрдэм шинжилгээний өгүүлэл, тойм өгүүлэл, товч тэмдэглэл, ном зохиолын шүүмж хэлбэрээр нэгтгэн цувралаар нийтэлдэг тогтмол хэвлэлийг,

1.4.2 “Эрдэм шинжилгээний өгүүлэл” гэж туршилт судалгааны үр дүнг боловсруулж, шинэ мэдээллээр баяжуулан нэгтгэж бичсэн шинжлэх ухааны бүтээлийг,

1.4.3 “Тойм өгүүлэл” гэж судалгааны тухайлсан чиглэлээр, эсвэл тодорхой нэг сэдвийн хүрээнд өмнө хийгдсэн судалгаанууд болон сүүлийн үед бий болсон шинэ мэдээлэл, бүтээл туурвилын талаар дүн шинжилгээ хийж, системчилж тоймлосон бүтээлийг,

1.4.4 “Товч тэмдэглэл” гэж судалгааны шинэлэг үр дүн, өвөрмөц арга зүй, шинэ технологи зэргийг агуулсан, шуурхай хэвлэж мэдээлэх шаардлагатай эрдэм шинжилгээний өгүүллийн богино хувилбарыг,

1.4.5 “Номын шүүмж” гэж сэтгүүлийн хамрах хүрээний чиглэлээр хэвлэгдсэн эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлагын агуулга, үр дүн, бичлэгийн талаар судлаач өөрийн шүүмж, санал, дүгнэлтээ илэрхийлсэн товч бичвэрийг,



1.4.6 “Хянан магадлагаа” гэж эрдэм шинжилгээний бүтээлийн үр дүнгийн бодит байдлыг баталгаажуулах, чанарыг сайжруулах зорилгоор хийдэг мэргэжил нэгт судлаачдын шүүмж, үнэлгээний арга хэлбэрийг,

1.4.7 “Редакцийн зөвлөл” гэж сэтгүүлийн хөгжил ба хэвлэлийн бодлого, хамрах чиглэлийг тодорхойлж, чанарыг хангах үүрэгтэй, мэргэжлийн салбартаа олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй эрдэмтдийн нэгдлийг,

1.4.8 “Зохиогчдод зориулсан заавар” гэж сэтгүүлийн зорилго, хэвлэлийн бодлого, хамрах чиглэл, хэвлэх бүтээлийн төрлүүд, бүтээлийн хулгайгаас сэргийлэх бодлого, өгүүллийг хүлээн авах ба хянан магадлах арга зам, өгүүллийн бүтэц, бичлэгийн загвар гэх мэт сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэхээр бэлтгэхэд баримтлах заавар, зохиогчдод зориулсан зөвлөмжийг,

1.4.9 “Тусгай дугаар” гэж сэтгүүлийн хамрах чиглэлийн хүрээнд тодорхой асуудал эсвэл сэдвийн хүрээнд бичигдсэн эрдэм шинжилгээний өгүүлүүдээс бүрдсэн сэтгүүлийн нэг дугаарыг хэлнэ. Тусгай дугаарт судалгааны тодорхой чиглэлээр өрнөж буй чухал асуудал буюу ‘халуун сэдэв’-ийг гүнзгийрүүлэн хэлэлцэж олон нийтийн хүртээл болгох, эсвэл эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн шилмэл илтгэлүүдийг сонгож өгүүлэл хэлбэрээр хэвлэнэ.

#### **ХОЁР. Эрдэм шинжилгээний сэтгүүлд тавигдах шаардлага**

2.1 Эрдэм шинжилгээний сэтгүүл тус бүр оноосон нэртэй байх ба шинжлэх ухааны чиглэл, агуулгын хувьд өөр хоорондоо давхцалгүй байна.

2.2 Аливаа шинжлэх ухааны чиглэлээр эрдэм шинжилгээний сэтгүүл шинээр бий болгох, нэр өөрчлөх, дахин зохион байгуулах асуудлыг дараах процессын дагуу шийдвэрлэнэ.

2.2.1 Судалгааны төв, хүрээлэн, бүрэлдэхүүн/салбар сургууль саналаа МУИС-ийн эрдэм шинжилгээ хариуцсан нэгжид хүргүүлнэ.

2.2.2 МУИС-ийн эрдэм шинжилгээ хариуцсан нэгж шинжлэх ухааны чиглэл, агуулга, сэтгүүлд тавигдах шаардлагын биелэлтийн талаар урьдчилсан дүгнэлт гаргана.

2.2.3 Судалгааны төв, хүрээлэн, бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөл МУИС-ийн эрдэм шинжилгээ хариуцсан нэгжээс гаргасан дүгнэлтийг үндэслэн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.2.4 Судалгааны төв, хүрээлэн, бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн МУИС-ийн эрдэм шинжилгээ хариуцсан нэгж МУИС-аас эрхлэн гаргах эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалтад бүртгэнэ.

2.3 Эрдэм шинжилгээний сэтгүүл тус их сургуулийн нэр, бэлгэ тэмдгийг ашиглаж болох ба энэ нөхцөлд “МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах журам”-ыг баримтална.

2.4 Эрдэм шинжилгээний сэтгүүл бүр өөрийн гэсэн загвар, форматтай байх ба нэг дугаарт 5-15 өгүүлэл хэвлэнэ. Сэтгүүлийг жилд нэг боть (ерөнхий дугаар), хэд хэдэн цувралаар (цувралын дугаар) хэвлэж болох ба тэдгээрийн аль аль нь тасалдалгүй дугаарлагдсан байна.

2.5 Эрдэм шинжилгээний сэтгүүл нь жил бүр тогтмол хэвлэгддэг байх ба (хэвлэмэл/онлайн хэлбэрээр) олон улсын цуврал бүтээлийн бүртгэлийн ISSN дугаартай (хэвлэмэл/онлайн) байна.

2.6 Эрдэм шинжилгээний сэтгүүл тухайн мэргэжлийн чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судлаачдаас бүрдсэн редакцийн зөвлөлтэй байна.

2.7 Сэтгүүл тухайн салбар шинжлэх ухааны тодорхой асуудлаар, эсвэл олон улсын эрдэм шинжилгээний хурлын шилмэл илтгэлүүдийг эмхэтгэн тусгай дугаар гаргаж болох ба энэ тохиолдолд уг дугаарыг эрхэлж хэвлүүлэх редакторыг урьж ажиллуулж болно.

2.8 Сэтгүүлд хэвлүүлэх өгүүллийн үр дүнгийн бодит байдлыг хангахын тулд бүтээлийн хулгайд тооцогдох, шинжлэх ухааны худал, хуурамч мэдээллийг нийтлэх, зохиогчийн эрхийг зөрчих зэрэг эрсдэлээс сэргийлсэн нийтлэлийн бодлого, арга хэрэгсэлтэй байна.

2.9 Эрдэм шинжилгээний сэтгүүл бүр вэб сайттай байх бөгөөд түүнд сэтгүүлийн хамрах шинжлэх ухааны чиглэл, зориулалт, хэвлэлийн бодлого зэргийг тусгасан танилцуулга, зохиогчдод зориулсан заавар (Журмын Заавар 1), өмнө хэвлэгдсэн бүх дугааруудын архив, редакцийн зөвлөлийн бүрэлдэхүүний мэдээлэл, холбоо барих хаяг зэрэг зайлшгүй шаардлагатай мэдээллийг байрлуулна. Холбоо барих и-мэйл хаяг нь МУИС-ийн албан ёсны @\*.num.edu.mn домэйнтэй байна.

2.10 Эрдэм шинжилгээний сэтгүүлүүд МУИС-ийн сэтгүүлийн нэгдсэн системийг ашиглан онлайн хэлбэрт шилжих, редакцийн зөвлөлийн үйл ажиллагааг цахимжуулна. Шаардлагатай бол сэтгүүлийн вэб сайтыг гадаадын сэтгүүлийн платформд байрлуулж болох бөгөөд энэ тохиолдолд сэтгүүлийн редакци МУИС-ийн эрдэм шинжилгээ хариуцсан нэгжид хэвлэгдсэн дугаарууд, хүлээн авсан өгүүлэл, хянан магадлагаа, нийтэлсэн өгүүлэл зэргийн статистик тайланг ирүүлнэ.

2.11 Сэтгүүлийг онлайнаар нээлттэй нийтлэх бол бүтээлийг нээлттэй ашиглах нөхцлийг (лиценз) тодорхой зааж өгнө. Тухайлбал, нээлттэй эхийн Creative Commons лицензийг (<https://creativecommons.org/about/cclicenses/>) сонгон ашиглаж болно.

2.12 Онлайнаар нээлттэй хэвлэгддэг сэтгүүлийг олон улсын нээлттэй сэтгүүлийн Directory of Open Access Journals (<https://doaj.org>) бүртгэлд бүртгүүлнэ.

#### **ГУРАВ. Эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцийн зөвлөл**

3.1 Сэтгүүлийн редакцийн зөвлөл нь ерөнхий редактор болон 10-аас цөөнгүй хүний бүрэлдэхүүнтэй гишүүдээс бүрдэх ба гишүүдийн 50 хүртэлх хувийг 2-3 жил тутамд шинэчилнэ. Сэтгүүлийн ерөнхий редактор нь олон улсын мэргэжлийн



сэтгүүлд өгүүлэл тогтмол хэвлүүлдэг туршлагатай эрдэмтэн байна. Ерөнхий редактор нь МУИС-ийн профессор эсвэл дэд профессор байна.

3.2 Сэтгүүлийн үйл ажиллагааг ерөнхий редактор бүхэлд нь хариуцах бөгөөд тэрээр сэтгүүлийн хөгжил ба хэвлэлийн бодлогыг тодорхойлох, редакцийн зөвлөлийн гишүүд ба зохиогчидтой харилцах, хянан магадлагаа хийх, сэтгүүлийг олон нийтийн хүртээл болгож сурталчлах зэрэг асуудлыг зохион байгуулах үүрэгтэй.

3.3 Редакцийн зөвлөлийн гишүүдийг ерөнхий редактор тухайн шинжлэх ухааны салбарын судлаачдын туршлага, нэр хүнд, мэргэжлийн чиглэл, сэтгүүлийн хамрах чиглэлд тохирох байдал зэрэг үзүүлэлтийг харгалзан сайн дурын үндсэн дээр урьж ажиллуулна. Редакцийн зөвлөлийг бүрдүүлэхдээ хүйсийн тэгш байдлыг хангах асуудлыг анхаарна.

3.4 Редакцийн зөвлөлийн бүрэлдэхүүнд нэр хүндтэй эрдэмтдийг (гадаад хэлээр хэвлэгддэг бол гадаадын эрдэмтдийг) урьж ажиллуулахыг эрхэмлэх ба сэтгүүлийн зорилго, мэргэжлийн чиглэлийн онцлогоос хамааруулж зөвлөлийн бүрэлдэхүүнд тэдний эзлэх хувь хэмжээ янз бүр байж болно.

3.5 Редакцийн зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.5.1 Сэтгүүлд ирүүлсэн өгүүлэлд хянан магадлагаа хийх ажлыг зохион байгуулж, хэвлэх эсэхийг шийдвэрлэх,

3.5.2 Сэтгүүлийн хэвлэлийн бодлого, хөгжлийн асуудлаар зөвлөгөө өгөх,

3.5.3 Тусгай дугаарын хамрах сэдэв, чиглэлийг тодорхойлж, түүнийг бусад мэргэжилтнүүдтэй хамтран гаргах,

3.5.4 Шинэ зохиогчдод зөвлөгөө өгч, бүтээлээ хэвлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх,

3.5.5 Сэтгүүлийг олон нийтэд сурталчлах, бүтээлийн хулгай, худал, хуурамч өгүүллээс сэргийлэх асуудлаар бусдад зөвлөгөө өгөх,

3.5.6 Хөндлөнгийн хянан магадлагч нар өгүүлийг хэвлэх эсэх асуудлаар санал зөрөлдсөн үед шийдвэр гаргахад ерөнхий редакторт туслах.

3.6 Редакцийн зөвлөл үйл ажиллагаагаа аливаа албан тушаалтан ба захиргааны нөлөөллөөс ангид явуулна. Ерөнхий редактор шаардлагатай үед редакцийн зөвлөлийг хуралдуулж хамтын шийдвэр гаргах хэлбэрээр асуудлыг шийдвэрлэнэ.

#### **ДӨРӨВ. Эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх**

4.1 Өгүүлэл хүлээн авах

4.1.1 Сэтгүүлийн редактор, зохиогч, хянан магадлагч хоорондын харилцааг хөнгөвчлөх, редакцийн үйл ажиллагааны ил тод, шуурхай байдлыг хангах зорилгоор өгүүлэл хүлээж авч хянан магадлагаа хийх, хэвлэх зориулалттай онлайн системийг ашиглахыг эрхэмлэнэ.

4.1.2 Зохиогч(ид) өгүүллийн эх бичвэр буюу гар бичмэлээ зохиогчдод зориулсан зааврын дагуу бэлтгэн редакцид ирүүлнэ.

4.1.3 Өгүүллийн хамт дагалдах захидлыг хавсаргаж эсвэл урьдчилан бэлтгэсэн маягтыг ирүүлэх бөгөөд түүнд тухайн өгүүлэлд тусгагдсан үр дүн нь хуурамч биш, зохиогчийн өөрийн туршилт судалгаагаар гарган авсан, өмнө нь хэвлэгдэж байгаагүй, бусдын бүтээлийг хууль бусаар ашиглаагүй, сэтгүүлийн зүгээс зохиогчдод тавигдах шаардлагыг хангасан байдал зэргийг батлан илэрхийлсэн байна.

4.1.4 Өгүүллийн үр дүнгийн бодит байдлыг үнэлэх, бүтээлийн хулгайнаас сэргийлэх зорилгоор редакцийн зөвлөлөөс урьдчилсан үнэлгээг хийнэ.

#### 4.2 Хянан магадлах/шүүмж авах

4.2.1 Эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлэхээр ирүүлсэн өгүүллийн эхний үнэлгээг сэтгүүлийн редактор хийх бөгөөд тухайн бүтээл нь сэтгүүлийн шаардлагыг хангасан байдал, хамрах чиглэлд нийцсэн эсэх, зохиогчдод зориулсан зааврыг баримталсан байдал зэрэгт үндэслэн дараагийн шатны үнэлгээ, хянан магадлагаа хийх эсэхийг шийдвэрлэнэ.

4.2.2 Редакцийн зөвлөлийн эхний үнэлгээгээр шаардлага хангаагүй хэмээн үнэлэгдсэн бүтээлийг хүлээн авахаас татгалзаж, зохиогчид буцаана.

4.2.3 Өгүүлэл бүрт хоёроос доошгүй судлаачаар хөндлөнгийн хянан магадлагаа хийлгэж, засаж сайжруулсны дараа хэвлэх эсэх шийдвэрийг ерөнхий редактор гаргана.

4.2.4 Хянан магадлагаа хийх явцад сонирхлын зөрчлөөс сэргийлэх зорилгоор зохиогчид болон хянан магадлагч нарын нэрсийг нууцална.

4.2.5 Хянан магадлагааг тухайн судалгааны чиглэлээр мэргэшсэн, редакцийн зөвлөлийн гишүүн бус судлаачаар хийлгэж болох бөгөөд, үүний тулд хөндлөнгийн шүүмж хийх боломжтой судлаачдын мэдээллийн санг сэтгүүлийн редакцийн зөвлөл бүрдүүлнэ.

4.2.6 Редактор нь бүтээлийг хэвлэхээр хүлээн авах эсэх, эсвэл шинэчилж өөрчлөн, засварласны дараа хэвлэх эсэхийг шийдвэрлэхдээ хянан магадлагааны үнэлгээг (Журмын Маягт 1) ашиглана.

4.2.7 Хянан магадлагааг хянан магадлагч нар, редакторын саналын дагуу 2 болон түүнээс дээш үе шаттайгаар явуулж болох бөгөөд энэ нь зохиогчийн зүгээс өгүүлээ хэрхэн засаж сайжруулсныг үнэлэх, дахин өөрчилж чанаржуулах боломжийг олгох зорилготой байна.

4.2.8 Шаардлага хангаагүй өгүүллийг хянан магадлагааны аль нэг шатанд зохиогчид буцаах ба уг бүтээлийг өөрчлөн сайжруулсны дараа сэтгүүлд хэвлүүлэхээр дахин ирүүлж болно.



4.2.9 Ерөнхий редактор шийдвэр гаргахдаа хянан магадлагаа хийсэн судлаачдын үнэлгээ болон редакцийн зөвлөлийн гишүүдийн санал, өгүүллийн чанар, шинжлэх ухааны түвшин зэрэгт үндэслэнэ.

#### 4.3 Хэвлэн нийтлэх

4.3.1 Сэтгүүлийн нүүр хуудсанд сэтгүүлийн нэр, ISSN дугаар, боть ба цувралын дугаар, хэвлэсэн он зэргийг бичнэ. Шаардлагатай нөхцөлд нүүр хуудсанд зураг оруулж болно.

4.3.2 Хянан магадлагааны үнэлгээ, редакторын шийдвэрээр хэвлэхээр зөвшөөрөгдсөн өгүүллийг хэвлэлийн эх бэлтгэлд шилжүүлж, хэвлэлийн эх буюу дардсыг зохиогчдод электрон хэлбэрээр илгээж хянуулна.

4.3.3 Хэвлэгдэхээр зөвшөөрөгдсөн өгүүллийн зохиогчийн эрхийг тусгай гэрээний (Журмын Маягт 2) үндсэн дээр сэтгүүлд шилжүүлэх ба ингэснээр хэвлэн нийтлэгч болон редакци сэтгүүлийг олон нийтэд түгээх, худалдан борлуулах эрхтэй болно. Үүний нэгэн адилаар зохиогч өөрийн хэвлүүлсэн бүтээлийг олон нийтэд түгээх, эх сурвалжийг эшлэх замаар ашиглах эрхтэй.

4.3.4 Нэгэнт хянан магадлагаа хийгдэж, хэвлэгдэхээр зөвшөөрөгдсөний дараа зохиогчийн зүгээс өгүүлэлд техникийн шинж чанартай засвараас өөр буюу агуулга, үр дүнгийн шинж чанартай өөрчлөлт оруулахыг хориглоно. Дардсыг хянасны дараа өгүүллийг эцсийн байдлаар хэвлэх бөгөөд онлайн сэтгүүлийн хувьд нэг дугаар бүрдэхийг хүлээлгүйгээр өгүүлэл тус бүрийг электрон хэлбэрээр хэвлэж болно.

4.3.5 Сэтгүүлийн цуврал дугаар, түүнд хэвлэгдсэн өгүүлэл болон холбогдох баримт, материал тус бүр тоон объектын дугаартай (DOI – Digital Object Identifier) байна. Мөн зохиогчдын ORCID дугаарыг өгүүллийн вэб хуудас, өгүүллийн эх бичвэр зэрэгт оруулж өгнө.


4.3.6 Зөвхөн хэвлэмэл хэлбэрээр нийтлэх сэтгүүлийн хувьд нэг дугаарт орох өгүүллүүдийг нэг дугаарт нэгтгэн хэвлэнэ.

4.3.7 Сэтгүүлийн хэвлэгдсэн дугааруудыг МУИС-ийн Номын санд хэвлэмэл ба онлайн хэлбэрээр тогтмол хадгалуулна.


4.3.8 Хэвлэгдсэн бүтээлүүдийг олон нийтэд түгээх, судлаачдын хүртээл болгох зорилгоор гадаад, дотоодын байгууллагуудтай сэтгүүлийг харилцан солилцох, түүнчлэн вэб сайт, цахим шуудан, нийгмийн сүлжээгээр дамжуулан сурталчилна.

4.3.9 Олон улсын мэдээллийн санд бүртгүүлэх зорилгоор өгүүллийн нэр, хураангуй, зохиогчдын нэрс зэргийг Англи хэлээр давхар нийтлэхийг, түүнчлэн эшлэл, эшлэсэн ном зохиолын жагсаалтад өгүүллийн латин үсгээр бичсэн эсвэл Англи хувилбарыг ашиглахыг эрхэмлэнэ.

4.4 Өгүүлэл хүлээн авах, хянан магадлах, хэвлэх ажил нь Журмын бүдүүвч 1-т үзүүлсэн дарааллын дагуу байна.



## ТАВ. Сэтгүүлийн санхүүжилт



5.1 Сэтгүүлийг хэвлэмэл ба онлайн хэлбэрээр олон нийтэд түгээх, олон улсын мэдээллийн санд бүртгүүлэх, холбогдох мэдээллийг тогтмол шинэчлэх, архивлах, хэвлэлийн эх бэлтгэх, өгүүлэлд хянан магадлагаа хийх, үнэлгээ өгөх, зэрэг редакцийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг МУИС, бүрэлдэхүүн/салбар сургууль, хүрээлэн, төвийн эрдэм шинжилгээний зардлаас санхүүжүүлнэ.

5.2 Хэвлэлийн зардалд сэтгүүлийн гадна нүүрийг 4 хүртэлх өнгөөр, үндсэн текстийг хар цагаанаар хэвлэх зардлыг багтаах ба ба харин электрон хувилбарыг өнгөтөөр хэвлэнэ.

5.3 Сэтгүүлийг худалдан борлуулах, хэвлэлийн захиалгад оруулах, гадаад дотоодын мэргэжлийн байгууллагуудтай солилцох ажлыг МУИС хэвлэлийн газар хариуцан зохион байгуулна.

## ЗУРГАА. Үнэлгээ

6.1 Сэтгүүлийг чанаржуулж улсдаа тэргүүлэх, улмаар олон улсын Web of Science, Scopus гэх мэт мэдээллийн санд бүртгэлтэй болгох бодлого баримтлах бөгөөд хэвлэгдсэн бүтээлийн чанар, эшлэлийн үзүүлэлт, олон улсын нэр хүнд зэрэг үзүүлэлтэд үндэслэн МУИС-ийн эрдэм шинжилгээ хариуцсан хоёр жил тутам үнэлгээ хийж эрэмбэлнэ.

6.2 Чанаргүй, шаардлага хангаагүй, худал, хуурамч үр дүн бүхий өгүүлэл хэвлэсэн, судалгааны ажлын ёс зүйг зөрчсөн, жил бүр тогтмол хэвлэгдэлгүй нэг жилээс дээш хугацаагаар тасалдсан зэрэг шалтгаанаар сэтгүүлийг хэвлэхийг зогсоох асуудлыг МУИС-ийн эрдэм шинжилгээ хариуцсан нэгжийн санал дүгнэлтэд үндэслэн судалгааны төв, хүрээлэн, бүрэлдэхүүн/салбар сургуулийн эрдмийн зөвлөл шийдвэрлэнэ.





**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛИЙН  
ЗОХИОГЧДОД ЗОРИУЛСАН ҮЛГЭРЧИЛСЭН ЗААВАР**

***Ерөнхий мэдээлэл***

Тус эрдэм шинжилгээний сэтгүүл нь ..... шинжлэх ухааны бүх салбарыг хамарсан эрдэм шинжилгээний өгүүллийг нийтэлдэг, хянан магадлагаа хийгддэг сэтгүүл юм. Сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүллээс гадна тойм өгүүлэл, товч тэмдэглэл, шинэ өгөгдөл, ном зохиолын шүүмж зэргийг хэвлэх боломжтой. Сэтгүүл зохиогчийн нас хүйс, эрхэлдэг ажил болон газарзүйн байрлалд хязгаарлалт хийхгүй.

Өгүүллийн хэвлэн нийтлэх хугацааг богиносгохын тулд хянан магадлагаа хийгдэж, хэвлэхээр зөвшөөрөгдсөн өгүүллийг эхлээд онлайн хэлбэрээр хэвлэнэ. Сэтгүүлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй <https://.....> хаягаар орж танилцана уу.

***Хянан магадлагаа хийх үйл явц***

Сэтгүүлд ирүүлсэн бүх гар бичмэлийг хоёроос доошгүй шүүмжлэгч уншиж хянан магадлагаа хийнэ. Гар бичмэлийг хүлээн авмагц ерөнхий редактор өгүүллийн агуулга, үр дүн, сэтгүүлийн шаардлагад нийцэж буй эсэх, зохиогчдоод зориулсан зааврыг баримталсан байдал зэрэгт урьдчилсан үнэлгээ хийж, шаардлага хангасан тохиолдолд мэргэжлийн шүүмжлэгчид хянан магадлагаа хийлгэхээр илгээнэ. Харин сэтгүүлийн шаардлагыг хангаагүй нөхцөлд гар бичмэлийг хүлээн авахаас татгалзаж, хариуг зохиогчид илгээнэ. Зохиогчид гар бичмэлээ сэтгүүлд ирүүлэхдээ хоёр болон түүнээс дээш тооны шүүмжлэгчийн нэрийг санал болгож болно.

***Өгүүллийн анхдагч байдал ба бүтээлийн хулгай***

Зохиогчид өөрсдийн туршилт судалгааны үр дүнд тулгуурлан анхдагч бүтээл туурвисан байх шаардлагатай бөгөөд хэрэв бусдын бүтээлийг ашигласан бол зохих ёсоор эш татсан байх ёстой. Бүтээлийн хулгай нь олон хэлбэртэй бөгөөд бусдын бүтээлийг өөрийн болгож хууль бусаар ашиглах, бусдын бүтээлийн тодорхой хэсгийг хуулбарлах, орчуулж ашиглах, бусдын хийсэн судалгааны үр дүнг өөрийнх хэмээн мэтгэх г.м. олон хэлбэртэй байдаг. Бүтээлийн хулгай нь аль ч хэлбэрээрээ ёс зүйгүй үйлдэл бөгөөд иймд түүнийг хүлээн зөвшөөрөх, хэвлэн нийтлэх боломжгүй юм. Сэтгүүлийн редактор гар бичмэлийг үнэлж, түүний агуулга болон зохиогчийн эрхийн асуудалтай холбоотой сэтгүүлийн стандартад нийцэхгүй зүйл илэрсэн тохиолдолд хэвлэхээс татгалзах шийдвэр гаргах эрхтэй. Тиймээс зохиогчид өөрсдийн гар бичмэлийг эх буюу анхдагч бүтээл, урьд өмнө хэвлэгдэж байгаагүй, бусад сэтгүүлд хэвлүүлэхээр илгээгээгүй болохыг илтгэх баталгааг сэтгүүлийн редакцид ирүүлэх шаардлагатай.

### **Хэвлэн нийтлэх нөхцөл ба зохиогчийн эрх**

Туршилт судалгааны үр дүнг бий болгох, боловсруулах, өгүүллийн гар бичмэлийг бичихэд тодорхой хувь нэмэр оруулсан судлаачдыг зохиогчийн жагсаалтад оруулах ёстой. Өгүүллийг бэлтгэхэд зохиогчид ямар хувь нэмэр оруулсныг тодорхойлсон байх шаардлагатай. Зохиогчийн эрх нь хамгаалагдсан бусад судлаачдын бүтээлийг ашиглах тохиолдолд бүтээлийг ашиглах, эх сурвалжаас хуулбарлах зөвшөөрлийг зохиогчид өөрсдөө авах үүрэгтэй.

Тус сэтгүүл нь онлайн нээлттэй хэвлэгдсэн бүтээлүүдийг Creative Commons Attribution-NonCommercial-NoDerivatives 4.0 International (CC BY-NC-ND 4.0 - <https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/>) лицензээр түгээх бөгөөд энэ нь арилжааны бус зорилгоор ашиглах, тарааж түгээх, хуулбарлахдаа анхдагч бүтээл болон зохиогчдоос эшлэл хийсэн тохиолдолд хязгаарлалтгүйгээр ашиглахыг зөвшөөрнө. Мөн энэ бүтээлд түшиглэн үүсмэл бүтээл гаргасан тохиолдолд түгээх, дамжуулах боломжгүй.

Энэхүү лицензээр зохиогчийн эрхийг алдагдуулахгүй, хязгаарлахгүй бөгөөд иймд зохиогчид өөрсдийн бүтээлийг хэвлэн нийтлэх эрхийг тус сэтгүүлд шилжүүлэх нөхцөл бүхий гэрээ байгуулна.

### **Сэтгүүлд доор дурьдсан бүтээлүүдийг хэвлэх боломжтой**

*Эрдэм шинжилгээний өгүүлэл:* ном зохиол, хүснэгт, зургийг оруулалгүйгээр 9000-аас илүүгүй үгэнд багтаж бичигдсэн байна. Эрдэм шинжилгээний өгүүлэлд хянан магадлагаа хийгдэнэ.

*Тойм өгүүлэл:* ном зохиол, хүснэгт, зургийг оруулалгүйгээр 11,000-аас илүүгүй үгэнд багтаж бичигдсэн байна. Тойм өгүүлэлд хянан магадлагаа хийгдэнэ.

*Товч тэмдэглэл:* нийт 3000-аас илүүгүй үгэнд багтаж бичигдсэн байна. Хянан магадлагаа хийх эсэхийг сэтгүүлийн редактор шийдвэрлэнэ.

*Шинэ өгөгдөл:* нийт 2000-аас илүүгүй үгэнд багтаж бичигдсэн байна. Сэтгүүлийн редакцийн хяналт үнэлгээгээр хэвлэх эсэхийг шийдвэрлэнэ.

*Номын шүүмж:* сэтгүүлтэй холбоотой шинэ номын товч тойм, шүүмж (1000 үгээр хязгаарлагдана). Сэтгүүлийн редакцийн хяналт үнэлгээгээр хэвлэх эсэхийг шийдвэрлэнэ.

### **Гар бичмэлийн зохион байгуулалт**

Гар бичмэлийг дараах дарааллаар бичнэ: Гарчиг, Товч гарчиг, Хураангуй, Түлхүүр үг, Оршил, Материал ба аргазүй, Үр дүн, Хэлэлцүүлэг, Талархал, Ашигласан ном зохиол.

Нүүр хуудас: Дараах мэдээллийг нүүр хуудсанд оруулах шаардлагатай.

*Гарчиг.* Энэ нь бүтээлийн агуулгыг илэрхийлэхүйцээр оновчтой томъёологдсон байх ёстой. Шаардлагатай нөхцөлд дэд гарчгийг нэмж болно.

*Товч гарчиг.* Таслал, тэмдгийг оролцуулан 50 тэмдэгтээс илүүгүй урттай товч гарчгийг онооно.

*Зохиогчид.* Зохиогч бүрийн овог нэр, байгууллагын харьяалал, цахим шуудангийн хаяг, ORCID-ийн дугаар.

*Харилцах хаяг.* Холбоо барих зохиогчийн шуудангийн хаяг, утас (олон улсын кодыг оруулна), цахим шуудангийн хаяг.



### Хураангуй

Өгүүллийн үндсэн үр дүн ба гол дүгнэлтүүдийг нэгтгэн, ажлын ач холбогдлыг илэрхийлэхүйц хураангуйлсан бичвэр. Хураангуй нь 200 үгээс хэтрэхгүй хэмжээтэй байна. Хураангуйд товчлол, эшлэл хийхээс зайлсхийнэ.

### Түлхүүр үгс

Онлайн хайлт хийх, өгүүллийн агуулгыг илэрхийлэх зориулалттай 8-аас илүүгүй түлхүүр үгийг (индексийн нэр томьёо) оруулна. Түлхүүр үгэнд гарчигт орсон үгсийг давтаж оруулахаас зайлсхийнэ.

### Оршил

Оршил хэсэгт тухайн чиглэлээр өмнө хийгдсэн судалгааны ажлыг тоймлон, улмаар өөрсдийн судалгааны зорилго, дэвшүүлсэн таамаглал зэргийг тусгана.

### Материал ба арга зүй

Энэ хэсэгт өөрсдийн судалгаанд ашигласан материал, цуглуулсан мэдээлэл, хийсэн ажиглалтын дүн мэдээг тусгана. Түүнчлэн хээрийн ба лабораторийн, туршилт ба ажиглалтын судалгаанд ашигласан арга техник, өгөгдөл ба түүврийг боловсруулсан статистикийн ба бусад аргыг дурьдана.

### Үр дүн

Үр дүнгийн хэсэг нь зөвхөн өөрсдийн бий болгож илрүүлсэн үр дүнгийн үзүүлэлтээр хязгаарлагдах бөгөөд бичвэр нь хүснэгт, зураг дээр өгөгдсөн мэдээллийг давхардуулж болохгүй, гэхдээ тэдгээрийг тайлбарлаж болно. Статистик үзүүлэлтийг оруулахдаа ашигласан шинжүүр, түүврийн хэмжээ, чөлөөний зэрэг, магадлалын түвшин зэргийг дэлгэрэнгүйгээр бичих хэрэгтэй, жишээлбэл: ANOVA:  $F_{3,17} = 108$ ,  $P < 0.0001$ ;  $\chi^2_{16} = 1190.6$ ,  $P < 0.0001$ ; Wilcoxon test:  $Z = 2.5$ ,  $N = 18$ ,  $P = 0.011$ ; Spearman rank correlation:  $r_s = 0.11$ ,  $N = 25$ ,  $P = 0.581$  г.м.

### Хэлэлцүүлэг

Хэлэлцүүлэгт үндсэн үр дүн, ололт, тэдгээрийн хүчин төгөлдөр байдлын талаарх хэлэлцүүлгийг ижил чиглэлээр өмнө нь хэвлэгдсэн бусад бүтээлүүдтэй харьцуулж дүгнэх, түүнчлэн ажлынхаа ач холбогдлын талаархи хэлэлцүүлгийг багтаасан байх шаардлагатай.

### Талархал

Судалгааг хийж гүйцэтгэхэд тусалж дэмжсэн хүмүүс, санхүүжүүлсэн байгууллага г.м.-д илэрхийлэх талархлын үгсийг оруулна

### Ном зохиол

Өгүүллийн бичвэрт эшлэлийг дараах байдлаар хийнэ:

*Нэг зохиогч:* Aoki (1990) эсвэл (Aoki, 1990);

*Хоёр зохиогч:* Beck and Woas (1993) эсвэл (Beck & Woas, 1993);

*Хоёроос дээш зохиогч:* Norton *et al.* (1993) эсвэл (Norton *et al.*, 1993).

Нэг жилийн хугацаанд нэг зохиогчийн хэвлүүлсэн хоёр болон түүнээс дээш тооны бүтээлийг ялгаж эшлэхийн тулд жижиг үсгийг нэмэлтээр ашиглана, жишээлбэл: Thompson and Heck (2002a, b) эсвэл (Thompson & Heck, 2002a, b). Бичвэрт олон бүтээлийн эшлэлийг он цагийн дарааллаар жагсааж бичнэ (цагаан толгойн дарааллаар бус) жишээлбэл: (Smith, 1985; Johnson, 1990; Beynon, 2001).

Бичвэрт эшлэсэн бүх бүтээлийг зохиогчийн нэрний эхний үсгийн дарааллаар жагсааж оруулна. Эшлэлийн жагсаалтад хамтран зохиогчдын нэрсийг



нэг бүрчлэн бичнэ.

Олон өгүүлэл бичсэн нэг зохиогчийн бүтээлийг он цагийн дарааллаар байрлуулна. Сэтгүүлийн нэрийг дэлгэрэнгүй хэлбэрээр нь бичих шаардлагатай. Түүнчлэн сэтгүүлийн дугаар боть(цуврал), өгүүллийн хуудасны дугаар зэргийг бичнэ.

Ном зохиолын жагсаалтад эш татсан бүтээлүүдийг дараах форматаар бичнэ. Үүнд:

Wiklund, C. G., Kjellen, N. & Isakson, E. 1998. Mechanisms determining the spatial distribution of microtine predators on the Arctic tundra. *Journal of Animal Ecology*, 67: 91–98.

Dhaliwal, G. S. 1970. Impact of chemical control on honey bees. *Pesticides (Bombay)*, 4(11): 17–19.

Cramp, S. & Simmons, K. E. L. 1980. *The Birds of the Western Palearctic*. Oxford University Press, Oxford, 356 pp.

Brothers, D. J. & Finnamore, A. T. 1993. Superfamily Vespoidea. In Goulet, H. & Huber, J. T. (eds.): *Hymenoptera of the World: An Identification Guide to Families*. Agriculture Canada, Ottawa, pp. 161–278.

### **Техникийн үзүүлэлтүүд**

#### **Хүснэгт**

Хүснэгт бүр дараалсан дугаар, түүнд багтаасан өгөгдлийн агуулгыг илэрхийлэх нэртэй байх ба хүснэгтийн мөрүүдийг нэг нэгжийн интервалын зайтай бичиж, дараалуулан дугаарлана. Нэмэлт мэдээллийг (жишээлбэл, статистикийн шинжилгээний үр дүн) хүснэгтийн доор зүүлт хэлбэрээр бичнэ. Зураг, хүснэгтийг бэлтгэхдээ хуудасны хэмжээнд багтахуйц буюу өргөн нь 160 мм, өндөр нь 240 мм, баганын өргөн нь 75 мм-ээс илүүгүй байхыг анхаарах шаардлагатай.

#### **Зураг**

Бүх зураг нэр, дугаартай байх ба нэр нь түүний агуулгыг товчоор илэрхийлсэн байх ёстой. Өгүүлэлд оруулах фото зураг нь өнгөт эсвэл хар-цагаан, хэвлэлийн шаардлага хангахуйц өндөр пиксельтэй байх шаардлагатай. Хүснэгт, зургийг текст дотор Зураг 1; Зураг 1-2; Хүснэгт 1; Хүснэгт 1-3 гэх мэтээр дурдах ба тэдгээрийн зохих байршлыг бичвэрт тэмдэглэнэ. Нэг ижил өгөгдлийг зураг ба хүснэгтэд давхардуулан оруулж болохгүй.

#### **Хавсралт**

Өгүүллийн агуулга, үр дүнтэй холбогдолтой тоон үзүүлэлт, хүснэгт, зураг зэрэг нэмэлт мэдээллийг хавсралтаар оруулж болно.

#### **Дардас ба хэвлэмэл материал**


Сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл, тойм өгүүлэл, товч тэмдэглэл, шинэ өгөгдөл, ном зохиолын шүүмж зэрэг бүх бүтээлийг үнэ төлбөргүй хэвлэх ба харин зохиогчид бүтээлээ өнгөтөөр хэвлүүлэхийг (хэвлэмэл хэлбэрээр) хүсвэл түүний хэвлэлийн зардлыг төлөх шаардлагатай.

Хэвлэгдэхээр зөвшөөрөгдсөн өгүүллийн дардсыг холбоо барих зохиогчид



илгээж хянуулна. Энэ шатанд зохиогч өгүүллийн үр дүн, өгөгдөл, агуулга зэргийг өөрчлөхүйц ямар нэгэн засвар өөрчлөлт оруулж болохгүй бөгөөд зөвхөн хэвлэлийн эх бэлтгэх явцад гарсан техник алдааг засах боломжтой.

Дардасыг хянаж дууссаны дараа өгүүллийг онлайнаар хэвлэж, цахим хувилбарыг зохиогчид PDF файл хэлбэрээр хүргүүлнэ.



### **Гар бичмэлийг сэтгүүлд ирүүлэх**

Хэрэв Та тус сэтгүүлд бүтээлээ хэвлүүлэхийг хүсвэл сэтгүүлийн вэб хуудсан дээрх онлайн мэдүүлгийн системийг ашиглана уу. Түүнчлэн Та .....@num.edu.mn цахим шуудангаар сэтгүүлийн редактортой холбоо барьж болно.

Та <https://.....> хаягаар вэб хуудсанд нэвтрэн зохиогчдод зориулсан зааврыг татаж авах боломжтой.

Дээрх удирдамжийг баримталж бэлтгээгүй гар бичмэлийг сэтгүүлийн редакци хүлээж авахаас татгалзан, зохиогчид буцаах болно.


Зохиогчийн эх хэл нь англиас өөр тохиолдолд гар бичмэлээ сэтгүүлд илгээхээсээ өмнө төрөлх англи хэлтэй судлаачаар уншуулж хянуулах шаардлагатай. Англи хэлний бичлэг муутай гар бичмэлийг хүлээж авахгүй. Өгүүллийн бичвэрт Америк эсвэл Британы зөв бичгийн дүрмийн аль нэгийг баримтална.

### **Зохиогчийн мэдүүлэг**

Зохиогч/холбоо барих зохиогч нь сэтгүүлд хэвлүүлэхээр ирүүлсэн гар бичмэлийг өөрсдийн судалгааны үр дүнд тулгуурлан бичсэн, уг бүтээлийг урьд өмнө хэвлүүлж байгаагүй, хэвлүүлэхээр өөр сэтгүүлд илгээгээгүй, бусдын бүтээлийг зохих журмын дагуу ашигласан, бүх зохиогчид гар бичмэлийг сэтгүүлд илгээхийг зөвшөөрсөн, судалгааны ажил нь ёс зүйн болон хууль ёсны шаардлагад нийцсэн болохыг баталсан батламж захидлыг сэтгүүлийн редакцид ирүүлнэ.



**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛД ӨГҮҮЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ, ХЯНАН МАГАДЛАГАА ХИЙХ, ХЭВЛЭХ ДАРААЛЛЫГ ХАРУУЛСАН БҮДҮҮВЧ.**







Маягт 1

..... СЭТГҮҮЛИЙН ХЯНАН МАГАДЛАГААНЫ ХУУДАС

**Ерөнхий редакторын нэр:** .....

**Зохиогчийн**

**нэр:** .....

**Өгүүллийн**

**нэр:** .....

**Шүүмжлэгчийн санал:**

1. Засвар өөрчлөлтгүйгээр хэвлэх
2. Бага зэрэг засварлах
3. Томоохон хэмжээний засвар оруулах
4. Хэвлэхээс татгалзах (шаардлага хангахгүй)
5. Бусад зөвлөмжүүд

**Тусгай тэмдэглэлүүд:**

1. Судалгааны өгөгдөл зохиогчдын өөрсдийн анхдагч өгөгдөл мөн үү? .....
2. Энэ өгүүлэл бүхэлдээ/хэсэгчилсэн байдлаар урьд өмнө хэвлэгдсэн эсэх? .....
3. Өгүүллийн нэр нь агуулгаа илэрхийлэхүйц товч, тодорхой бичигдсэн эсэх? .....
4. Хураангуй нь өгүүллийн гол агуулга, үр дүнг илэрхийлж чадсан эсэх? .....
5. Олон улсын хэмжилтийн нэгж болон бусад нэр томъёог зөв хэрэглэсэн эсэх? .....
6. Судалгаанд хэрэглэсэн арга зүй өнөөгийн шаардлагад нийцсэн эсэх? .....
7. Судалгааны өгөглөө статистик аргаар хангалттай боловсруулсан эсэх? .....
8. Үр дүнгийн тайлал, тайлбар зөв бичигдсэн эсэх? .....
9. Хэлэлцүүлэг, дүгнэлт нь үр дүнгээ дэмжихүйц зөв бичигдсэн эсэх? .....
10. Хүснэгт, зурагууд зайлшгүй шаардлагатай өгөгдлийг агуулсан эсэх? .....
11. Гар бичмэлийн зарим хэсгийг өөрчлөх, өргөтгөх, хасах шаардлагатай юу? .....
12. Гар бичмэлийн нийт урт нь агуулгатайгаа нийцэж байна уу? .....
13. Өгүүллийн бичлэг, найруулга хангалттай сайн эсэх? .....
14. Шаардлагатай ном зохиолыг бүрэн ашиглаж эш татсан эсэх? .....
15. Бусдын бүтээлийг зохиогчийн эрхийг нь зөрчилгүй ашигласан эсэх? .....

**Нэмэлт санал, шүүмж:**

.....

.....

.....

.....

.....

.....

.....



Энэхүү гар бичмэлийн хянан магадлагааг цаг хугацаанд нь хийж, шүүмж бичиж өгсөн Танд баярлалаа.





## ЗОХИОГЧИЙН ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

Сэтгүүлийн нэр: .....  
Ерөнхий редакторын нэр: .....  
Өгүүллийн нэр: .....  
Зохиогчдын нэрс: .....

### Зохиогчийн эрх ба ёс зүйн батламж:

- 1) Бүх зохиогчид энэхүү өгүүллийг уг сэтгүүлд хэвлүүлэхийг зөвшөөрч байгаа бөгөөд аливаа асуудлаар сэтгүүлийн редакцитай харилцаж, шийдвэрлэхийг холбоо барих зохиогчид итгэмжилсэн болно.
- 2) Энэхүү өгүүлэл урьд өмнө хэвлэгдэж байгаагүй бөгөөд цаашид өөр хэвлэлд давтагдаж хэвлэгдэхгүй болохыг баталж байна.
- 3) Энэхүү өгүүлэл нь аливаа хувь хүн, аж ахуйн нэгжийн зохиогчийн эрх болон бусад эрхийг зөрчөөгүй бөгөөд бусдыг доромжилсон, гүтгэлгийн шинжтэй, залилан мэхлэлтийн шинжтэй г.м. хууль зөрчсөн ямар нэг мэдээллийг агуулаагүй болно.

### Зохиогчийн эрхийн шилжүүлэг

- 1) Зохиогчид өгүүллээ хэвлэмэл болон цахим хэлбэрээр хэвлэн нийтлэх, олон нийтэд түгээх, худалдан борлуулах эрхийг сэтгүүл болон хэвлэлийн газарт шилжүүлэв.
- 2) Сэтгүүл болон хэвлэлийн газар нь хэвлэгдсэн өгүүллийг арилжааны бус зорилгоор олон нийтэд түгээх, анхдагч эх сурвалжийг эшлэсэн тохиолдолд бусад бүтээлдээ нээлттэйгээр ашиглах эрхийг зохиогчдод олгов.

Ерөнхий редакторын гарын үсэг \_\_\_\_\_ Огноо \_\_\_\_\_

Холбоо барих зохиогчийн гарын үсэг \_\_\_\_\_ Огноо \_\_\_\_\_

Баталгаа (шаардлагатай нөхцөлд) \_\_\_\_\_ Огноо \_\_\_\_\_